



ГОЛОМТ БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2024 оны 04 сарын 15 өдөр

№ 00/01

Улаанбаатар хот

Голомт банкны 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.7, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Голомт банкны дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2.8 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 сарын 15-ны ээлжит хурлын санал хураалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүн, түүнийг баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГАНБОЛД



ГОЛОМТ БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2024 оны 04 сарын 15 өдөр

№ 00/02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дахь заалт, Голомт банкны дүрмийн 8.2.12 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 сарын 15-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГАНБОЛД



Голомт банкны 2024.04.15-ны
ХЭХ-ын 00/102 тоот шийдвэрийн
Хавсралт №1
902305
GOLOMT BANK

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн	Цалин 2024 төсөв	Жилд нийт	1,199 сая ₮
---	---------------------	-----------	-------------



ГОЛОМТ БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2024 оны 04 сарын 15 өдөр

№ 00/03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 сарын 15-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан дор дурдсан нэр дэвшигчдийг “Голомт банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр 2027 оны ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл гурван жилийн хугацаатай сонгосугай.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
 - Чүлтэмийн Мөнхцэцэг;
 - Жигжидийн Үнэнбат;
 - Урс Э. Шварценбах;
 - Дагвын Мөнхтөр;
 - Очирпүрэвийн Ганжолоо.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 - Жэймс Б. Дваер;
 - Александр Пикер;
 - Роберт В. Ван Звитен;
 - Ханс Холзхакер.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд холбогдох хууль тогтоомж, банкны дүрэм, компанийн засаглалтай холбоотой журмуудыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаар олон нийтэд мэдээллэж, гишүүдийн мэдээллийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /З.Солонго/-д даалгасугай.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдтэй хөдөлмөрийн харилцааг зохицуулах гэрээний нөхцөлийг тохирч, гэрээнд банкныг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ч.Мөнхцэцэг/-д олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г ГАНБОЛД



ГОЛОМТ БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2024 оны 04 сарын 15 өдөр

№ 00/04

Улаанбаатар хот

“Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр” хэрэгжүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8, 62 дугаар зүйлийн 62.1.8, 62.1.15 дахь заалт, Голомт банкны дүрмийн 8.2.12 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 сарын 15-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн зарласан хувьцааны хүрээнд Голомт банкны ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нэмж гаргах энгийн хувьцаанаас хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
3. Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх нөхцөл, хэмжээ, хувьцаа эзэмшүүлэхтэй холбоотой журмыг батлах, энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГАНБОЛД